

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын эрх зүйн асуудал, мэдээллийн сан, тайлагнал хариуцсан ахлах шинжээч, Чимэдрэгзэн Баярмаа

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Боловсрол, шинжлэх ухааны хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах							
1	Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, гэрээ, хэлэлцээрийн төслийг бусад хууль тогтоомжид нийцүүлэн хянах	Сайд, Төрийн нарийн бичгийн даргын батлах захиргааны шийдвэрийн эрх зүйн үндэслэл хангагдсан байна.	2023 онд 319 тушаал шийдвэрийн төслийг хянасан.	2023 онд 126 тушаал шийдвэрийн төслийг хянасан.	Нийт 4 ажлыг үүнд хамааруулан тайлагнаж байна.. 1.Тушаал хянасан. Тайлант хугацаанд 156 тушаалын үндэслэлийг хянаж эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж ажилласан. Үүнээс БШУС-н 136, ТНБД-н 20 тушаалын төслийг хянасан байна. Нийт 156 тушаалыг хувьчилбал 30 хувь захиргааны хэм хэмжээний актын төсөл, 20 хувь хүний нөөцтэй холбоотой төсөл, 30 хувь зардал гаргах, 20 хувь нь холбогдох хууль тогтоомжийг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ажлын хэсэг байгуулах зэрэг агуулга бүхий байв. Захиргааны хэм хэмжээний актын төслийг холбогдох хууль дүрмийн хүрээнд боловсруулах, зохих шаардлагыг хангуулах санал өгч 1-2 удаа боловсруулсан мэргэжилтэнд буцаан сайжруулсан. Энэ хүрээнд дүрэм журмын боловсруулалт сайжирч ХЗДХЯ-д бүртгүүлэхээр хүргүүлсэн дүрэм, журамд аливаа дүгнэлт бүхий албан бичиг ирж байгаагүй нь баталсан дүрэм журмууд хуульд нийцэж байгааг илтгэх юм. 2023 оны эхний хагас жилтэй харьцуулахад 30 тушаал илүү хянасан байна. 2.Журмын төслийн хэлэлцүүлэг. Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд журмын төслийн хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулж, 7 удаа оролцож хуульд нийцүүлэх санал өгсөн. 3.нийт 7 ажлын хэсэгт гишүүнээр ажилласан. үүнд 1.Зөвшөөрлийн		
--	--	--	--	--	---	--	--

					магадлан шалгах ажлын хэсгийн гишүүнээр ажиллав. Нийт 4 сургуулийн орчинтой танилцаж, цахимаар 16 сургуулийн баримт бичгийг судлаж 14 сургуульд зөвлөмж өгч баримт бичгээ дахин сайжруулж шаардлага хангасны дараа зөвшөөрлийг олгох талаар дүгнэлтэд санал өгсөн. Шийдвэрлээгүй 2 сургуулийн зөвшөөрөл байна. 2.Аймгийн БШУГ-н даргыг сонгон шалгаруулах Комисст гишүүнээр ажилласан. /Говь-Алтай Хөвсгөл Сүхбаатар/ 3.Увс аймгийн БШУГ н даргын ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсэг. 4.Дохионы хэлний хуулийн төслийг хүлээн авах ажлын хэсэгт ажиллаж хуулийн, үзэл баримтлалын төсөл, тандан судалгаанд сайжруулах санал өгсөн. 5.БСБ-н бүртгэл нэршлийг цэгцлэх ажлын хэсэгт гишүүнээр ажилласан. 6.Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байна. 7.Батлах эрх олгосон заалтад дүн шинжилгээ		
--	--	--	--	--	---	--	--

					хийх ажлын дэд хэсгийн нарийн бичгийн дарга. Хавсралт: 7 файл		
2	салбарт нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг мэдээллийн санд оруулах, өөрчлөлт, хөдөлгөөнийг тогтмол хөтлөх, салбарын хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн сан бүрдүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулна.	мэдээллийн санг бүрдүүлсэн байдал	Салбарт мөрдүүлэхээр нийт 9 журам захиргааны хэм хэмжээний актад бүртгэгдсэн.	Салбарын шинээр батлагдсан хууль бусад хуульд нийцүүлж шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох ЗХХА-ын нэгдсэн жагсаалтыг шинэчилсэн байна.	1.Тайлант хугацаанд салбарт мөрдөх захиргааны хэм хэмжээний актын мэдээллийн сангийн хөдөлгөөнийг тогтмол хөтлөн санг бүрдүүлж, сурталчлах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. 1.Яамны эрхлэх асуудалд хамаарах салбарын санг эрхлэн хөтөлж ХЗДХЯ с ирүүлсэн албан бичгийг үндэслэн жагсаалтад өөрчлөлт оруулж мөн яамны нийт албан хаагчдад тухай бүр албаны имэйл хаягаар хүргүүлсэн. Салбарын хэмжээнд нийт 52 захиргааны хэм хэмжээний акт үйлчилж байна. жагсаалтыг хавсаргалаа. 2.Хууль шинэчлэн батлагдсанаас хойш батлах захиргааны хэм хэмжээний актын тоог салбар бүрээр гарган яамны удирдлагыг мэдээллээр хангаж ажиллав. жагсаалтыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хавсаргав. 3.Хуулиар батлах эрх олгосны дагуу батлах эрх зүйн актын төлөвлөгөөг холбогдох нэгжийн дарга мэргэжилтний саналын дагуу нэгтгэн холбогдох нэгжүүдэд хүргүүлж ажиллав. төлөвлөгөөг хавсаргав. 4.Хуулиар батлах эрх олгосон ч батлаагүй, боловсруулаагүй захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг гарган яамны удирдлагад хүргүүлсэн. Одоогоор 20 захиргааны хэм хэмжээний актыг боловсруулж батлах шаардлагатай байгаа. жагсаалтыг хавсаргалаа. 5.Тайлант хугацаанд дээрх ажлыг хийж гүйцэтгэснээс гадна тухай бүр яамны БНБТГ, ТЗУГ, ТНБД нэгжийн даргад захиргааны хэм хэмжээний актын талаарх танилцуулгыг боловсруулан мэдээллээр ханган ажиллав. Танилцуулгыг хавсаргав. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад захиргааны хэм хэмжээний актын	
--	--	--	--	--	--	--

					жагсаалт хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулж бүрэн шинэчлэгдсэн бөгөөд энэ жагсаалт нийтээр дагаж мөрдөх журмын нэгдсэн сан болох legalinfo.mn сайттай тулж байгаа болно. 2.МБШУҮЭ тэй хамтран 21 аймаг, 9 дүүрэгт боловсролын багц хуулийг сурталчлах ажлыг хамтран зохион байгуулах ажилд оролцож нийслэлийн 2 дүүрэг, 3 аймагт БЕХ, ДБТХ-н танилцуулгыг хийв. Энэ хүрээнд сургагч багш нарт хууль сурталчлах ажилд анхаарах асуудлыг бэлтгэн танилцуулсан. ТНБД н батлах тушаалыг албажуулсан. Файл хавсаргалаа. Энэ ажлын хүрээнд яамны зхха-г тухай бүр яамны сайтад шинэчлэн байршуулсан. Хавсралт: 8 файл		
1.2. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах							
3	Зөвшөөрлийн тухай хууль хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн	хуулийн төсөл боловсруулсан байна.	Ажлын хэсэг байгуулагдсан байна.	Үзэл баримтлалын төсөл батлагдсан	Энэхүү ажлын хүрээнд 2 хуулийн төслийн Үзэл баримтлалыг боловсруулахад	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р	Өөрийн үнэлгээ: 70% Нэгжийн

	төсөл, тухай нэмэлт, оруулах төсөл боловсруулна. Зөрчлийн хуульд өөрчлөлт хуулийн			байна.	ажилласан. Энэхүү 2 хуулийн төслийг тус бүрт нь дэлгэрэнгүй байдлаар доор дурдсанаар тайлагнав. 1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан. Гэхдээ тус хуулийн төслийн Үзэл баримтлалын төсөл, Хуулийн хэрэгжилтийн үр дагаварын судалгааг бие даан боловсруулж ажилласан. Үүний хүрээнд ХЗДХЯ аас ирүүлсэн саналын дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны Инновацийн бодлогын газрын дарга Золзаяатай 3 удаа уулзаж салбарын зөвшөөрлийн асуудлыг танилцуулсан. ЭЗХЯ аас дээрх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан тул тус ажлын хэсгийн 2 удаагийн хуралд оролцсон. Одоогоор Эдийн засаг, хөгжлийн яамнаас Ерөнхий сайдын дэргэдэх зөвшөөрлийн зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх	сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
--	---	--	--	---------------	---	--	---

					ажил хүлээгдэж байна. Манай яамнаас Эдийн засаг, хөгжлийн яаманд байгуулагдсан ажлын хэсэгт БНБТГ н дарга П.Оюунаа, ДББУҮГ н дарга Х.Тамир, нэгжийн даргаас өгсөн чиглэлийн дагуу миний бие тус тус оролцон салбарын зөвшөөрлийн асуудлаар зохих мэдээллийг өгч ажиллаж байна. Ирэх сард ЭЗХЯ -с Зөвшөөрлийн зөвлөлд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулгыг хийхээр ажиллаж байгаа болно. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Үзэл баримтлал, танилцуулга, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн судалгааг хийсэн боловч ЭЗХЯ ны эрхлэх асуудалд хамаарах тул манай яам дангаараа боловсруулж батлах боломжгүй тухай ХЗДХЯ с чиглэл ирүүлсэн байгаа. Холбогдох албан бичиг, бие даан хийж гүйцэтгэсэн судалгаа, үзэл баримтлалын төслийг		
--	--	--	--	--	---	--	--

					тус тус хавсаргалаа. 2.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ХХАХҮЯ -с боловсруулж санал авахаар ирүүлсэн байх бөгөөд тус үзэл баримтлалын төслийг сайжруулах салбарын онцлогт нийцүүлэх зэрэг асуудалд саналаа өгч ажилласан. Мөн ТНБД д үзэл баримтлалын төсөл танилцуулах хуралд оролцсон. Хавсралт: 4 файл		
1.4. Хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх							
4	Салбарт хамаарах асуудлаар яам болон сайдад холбогдох шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яамыг төлөөлж итгэмжлэлээр оролцоно.	Оролцсон байдал	Шүүх дээр хянан хэлэлцэгдэж буй нийт 13 хэрэгт төлөөлөл хэрэгжүүлэн оролцсон	Яамны итгэмжлэлээр оролцох оролцоог бүрэн хангаж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хангаж ажилласан байна.	Тайлант хугацаанд нийт 3 захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж байна. Эдгээрээс эцэслэн шийдвэрлэгдсэн 2 хэрэг маргаан, хянан шийдвэрлэх шатанд байгаа 1 хэрэг маргаан байна. Эцэслэн шийдвэрлэсэн 2 маргаанд: 1.Иргэн Ц.Гансүхийн БШУС-н 2023 оны 1а/3347 дугаартай албан бичигт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					залруулга хийх агуулга бүхий БШУС-д холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг хянан хэлэлцээд Анхан шатны шүүхийн 2023 оны 12 сарын 05-ны өдрийн 10027 дугаартай захирамжаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. Нэхэмжлэгч тус захирамжид гомдол гаргасны дагуу Давж заалдах шатны шүүхийн 2024.01.11-ний өдрийн 221/АГ12024/54 дугаартай тогтоолоор "Хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж" шийдвэрлэсэн. 2.Хил хязгааргүй хуульчид ТББ-н "3 багц асуудлаар хуулийн хугацаанд бичгээр хариу өгөөгүй БШУС н эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, хариу өгөхийг даалгах" агуулга бүхий нэхэмжлэлийг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх хянан хэлэлцээд нэхэмжлэлийг		
--	--	--	--	--	---	--	--

					бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. Нэхэмжлэгч тал давж заалдах гомдол гаргаагүй тул шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж эхлэсэн байгаа. Хянан шийдвэрлэх шатанд явж байгаа иргэн Ж.С-н нэхэмжлэлийг анхан шатны шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэснийг нэхэмжлэгч тал давж заалдах гомдол гаргасан. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхэд буцаан шийдвэрлэснийг эс зөвшөөрч хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Одончимэг, Ч.Баярмаа нар УДШ-д Давж заалдах шатны шүүхийн магадлалд гомдол гаргасан. УДШ гомдлыг хянан хэлэлцээд хариуцагчийн гаргасан гомдлыг ханган анхан шатны шүүхэд шилжүүлсэн Давж заалдах магадлалыг хууль бус гэж үзэн Давж заалдах шатны шүүхэд буцаан шийдвэрлэсэн. Одоо Давж заалдах шатны шүүхэд хянан хэлэлцэх үйл ажиллагаа		
--	--	--	--	--	--	--	--

					үргэлжилж байна. Холбогдох шийдвэрүүдийг хавсаргалаа. Хавсралт: 3 файл		
1.5. Төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалах үүнтэй холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах							
5	Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, ашиглах, хадгалах үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулна.	Төрийн болон албаны нууцын баримт бичиг, түүний хадгалалт хамгаалалтын хэвийн үйл ажиллагаа хангагдсан байдал	Салбарын нууцын журам болон нууцад хамаарах мэдээлэл болон танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн батлуулсан.	Батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	Боловсролын мэдээллийн технологийн төвийн нийт албан хаагч болон гэрээгээр ажиллаж байгаа өгөгдлийн хөгжүүлэгч нарт төрийн болон албаны нууцын хууль тогтоомж, салбарын төрийн болон албаны нууцын жагсаалтыг бусад холбогдох шийдвэрүүдийг танилцуулж танилцуулах уулзалтыг зохион байгуулж ажилласан. Мөн нууцтай танилцахдаа зохих нууцлалын баталгааг гаргуулах, хууль тогтоомжийн хүрээнд нууцыг задруулахгүй байхад анхаарч ажиллахыг сануулсан. бусад холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль болон бусад хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, мэдлэг чадвараа тасралтгүй хөгжүүлнэ	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль болон бусад хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, мэдлэг чадвараа тасралтгүй хөгжүүлнэ	-	Худалдан авах ажиллагааны А-3 гэрчилгээ олгох сургалтад хамрагдаж гэрчилгээтэй болсон байна.	Тайлант хугацаанд нийгмийн даатгалын багц хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, хүүхэд хамгааллын хууль тогтоомжуудыг судлан ажилласан. Мөн хувийн хэрэгцээндээ нийцүүлэн Органик бүтээгдэхүүний тухай хуулийг судлан ажилласан. Худалдан авах ажиллагааны А-3 гэрчилгээ олгох сургалтад хамрагдсан. Шалгалт өгч амжаагүй байна. Яамны холбогдох нэгжүүдээс зохион байгуулсан 5 удаагийн мэдээллийн цагт хамрагдсан. Төрийн албанаас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдсан. Япон Улсын төрийн албаны талаарх асуудлаар сургалт хийсэн. Мөн тус газраас зохион байгуулсан Төрийн зүтгэлтнүүдийн талаарх	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

					сургалтад хамрагдсан. Тус сургалтыг Чингисийн музейн захирал С.Чулуун хөтлөн явуулсан.		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын эрх зүйн асуудал, мэдээллийн сан, тайлагнал хариуцсан ахлах шинжээч, Чимэдрэгзэн
Баярмаа /...../ Огноо: